

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

Чавганы суулгац. Техникийн шаардлага	MNS 6372 : 2013
Plum seedlings. Technical requirement	

Стандарчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг 2013 оны 3 дугаар сар 29-ний өдрөөс эхлэнэ мөрдөнө.

1. ХАМРАХ БА ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

1.1 Энэхүү стандарт нь чавганы суулгац үржүүлэх, шалгаж хүлээн авах, савлах, борлуулах, импортлох, хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаанд хамаарна.

1.2 Энэ стандартыг баталгаажсан технологийн дагуу чавганы суулгацыг үржүүлдэг мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд болон хяналт шалгалтын эрх бүхий байгууллагууд, худалдан авагчид хэрэглэнэ.

1.3 Энэхүү стандарт нь чавганы үндэсний шижим, ногоон мөчир, модлог мөчир, үр, үндэсний хэсгээр үржүүлсэн суулгацад хамаарахгүй.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад дараах баримт бичгийг эш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас эш татаж хэрэглэнэ.

- MNS 4220:1994, Жигдийн тарьц, техникийн шаардлага,
- ГОСТ 13853:78, Яст болон үрт жимст модны үр, тариалалтын чанар. Техникийн нөхцөл,
- ГОСТ24835:81, Интоорын, тарьц суулгац, тариалалтын чанар,
- MNS 6250:2011, Чацарганы суулгац, техникийн шаардлага,
- MNS 6251:2011, Үхэр нүдний суулгац, техникийн шаардлага.

3. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Чавганы суулгац

Үржүүлгийн эх цэцэрлэгээс ургал эрхтнээр нь үржүүлэн гаргаж авсан, жимст цэцэрлэг байгуулахад зориулсан хоёр настай суулгац,

3.2 Жимст цэцэрлэг

Жимс хурааж авах зориулалттай цэцэрлэг,

3.3 Үржүүлгийн эх цэцэрлэг

Үржүүлэгт зориулан мөчир авахаар шигүү тариалсан цэцэрлэг,

3.4 Ургал эрхтний үржүүлэг

Мөчир, нахиа залгаж үржүүлсэн үржүүлэг,

3.5 Залгаадас

MNS 6372 : 2013

Үржүүлгийн эх цэцэрлэгээс авсан нахиа, мөчрийг залгаадас,

3.6 Залгуурга

Өрлийн үрээр тарьсан 2 настай тарьц,

3.7 Нахианы залгалтын суулгац

Үржүүлгийн зориулалттай эх цэцэрлэгээс модны шүүс гүйлтийн идэвхтэй үе буюу 8 сарын эхний 10 хоногт ургасан нахиаг авч урьдчилан бэлтгэж ургуулсан өрлөн залгуурганд шигтгэж ургуулсан гурван настай суулгац,

3.8 Мөчрийн залгаадасны суулгац

Үржүүлгийн зориулалттай эх цэцэрлэгээс модны шүүс гүйлтийн идэвхитэй үе буюу 5 сарын 5-аас 15 ны хооронд нэг наст мөчрийг өрлөн залгуурган дээр залгаж ургуулсан гурван настай суулгац,

3.9 Бойжуулгын талбай

Нахиа, мөчир залгасан 2 настай тарьцыг суулгац болтол нь ургуулах тусгайлан бэлтгэсэн талбай,

3.10 Механик гэмтэл

Мөчир, салаа иш, үндэс, холтсонд үүссэн шалбархай, хугарал, бяцрал, халцрал,

3.11 Амь чийг

Мөчир салаа иш, үндэс хорчийж, чийг алдагдлын шинж тэмдэг илрээгүй байдал,

3.12 Шилбэ

Үндэсний хүзүүнээс хамгийн доод талын мөчир хүртэлх хэсэг,

3.13 Суулгацын өндөр

Шилбэнээс мөчрийн орой хүртэлх хэмжээ,

3.14 Чавганы гуалилт

Podosphaera tridactyla (Wallr.) De bary - Навч, мөчрийг өвчлүүлнэ. Навчин дээр шаравтар өнгөр үүснэ. Өвчилсөн навчинд намар 85-аас 100 мкм диаметртэй, бөмбөлөг хэлбэрийн клейстохарпийн мөөг бий болдог.

3.15 Чавганы улаан толбожилт

Polystigma rubrum (Pers.) - Навч өвчилнө. Навчин дээр улаан өнгийн толбо бий болно. Ургалтын бүх хугацаанд өвчний халдвар явагдах ба заримдаа хавар 4 сарын сүүлч сарын эхээр өвчний спор тархах тохиолдол байдаг. Өвчний халдвар нэмэгдэхэд навч хүрээнтэн хатаж унадаг.

4. Ангилал

4.1 Үржүүлсэн аргаас нь хамааруулж чавганы суулгацыг

- Нахианы,
- Мөчрийн гэж ангилна

4.2 Үндэсний систем болон газрын дээрх хэсгийн чанар, гадаад шинж тэмдгийн үзүүлэлтээр нь хоёр зэрэгт хуваана.

5. Техникийн шаардлага

- 5.1 Чавганы суулгацыг баталгаажсан технологийг баримтлан үржүүлнэ.
- 5.2 Чавганы үржүүлгийн эх цэцэрлэгт сортын хянан баталгаа хийсэн байна.
- 5.3 Чавганы суулгац нь сортын шинж чанараа бүрэн хадгалсан, бусад сортын хольцгүй байна.
- 5.4 Чавганы жимслэх болон үржүүлгэнд ашиглах эх цэцэрлэг байгуулахад мөчрийн болон нахиа залгах аргаар үржүүлсэн гурван настай нэгдүгээр зэргийн суулгацыг тариална.
- 5.5 Үрээр үржүүлсэн суулгацыг селекцийн эх материал гаргахад ашиглана.
- 5.6 Чавганы суулгацын чанарын үзүүлэлт дараах хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

Чавганы суулгацын чанар, гадаад шинж тэмдгийн үзүүлэлтүүд

д/д	Үзүүлэлт	Суулгацын шинж тэмдэг	Зэрэг	
			I	II
Үндэсний систем				
1	Үндэсний урт	см-ээс багагүй	60	50
2	Голч	см-ээс багагүй	0,8	0,6
3	Өнгө	Хүрэн		
4	Залгалтын байдал	Залгалт эдгэрсэн байх		
Газрын дээрх хэсэг				
1	Мөчрийн тоо	ш-ээс цөөнгүй	2	1
2	урт	см-ээс багагүй	80	60
3	голч	см-ээс багагүй	1,5	1,2
4	өнгө	Хүрэн бор		
5	Гадаад байдал	Шилбэнээс 10 см орчимд залгалт ил харагдаж байх, үндсэн салаа мөчрийн гадаргуу нахиа шалбарч гэмтээгүй, үндэс харлаагүй, амь чийгтэй		
6	Өвчин, хөнөөлт шавьжинд нэрвэгдсэн байдал	Илрэх ёсгүй		

ТАЙЛБАР 1: Чавганы II-р зэргийн шаардлагад хүрэхгүй суулгацыг мод үржүүлгийн газрын бойжуулгын талбайд тарина.

ТАЙЛБАР 2: Хадгалалт, тээвэрлэлтийн үед чавганы суулгацын нахиа ба холтос нь 5%-иас хэтрэхгүй механик гэмтэлтэй байхыг зөвшөөрнө.

6. ДЭЭЖ АВАХ

Суулгацын стандартын дээрх хүснэгтэд заасан чанарыг баримтлан нийт суулгацын 10-аас доошгүй хувийг шалгаж хүлээн авна.

7. ШАЛГАЖ ХҮЛЭЭЖ АВАХ

7.1 Чавганы суулгацыг тарихын өмнө буюу хавар 5-р сарын эхний арав хоногт, 10-р сарын дунд арав хоногт багтаан шалгана.

MNS 6372 : 2013

7.2 Суулгацын 25 буюу 50 ширхэгээр багцалсан боодол тутмаас 10%-иас доошгүй хувьд дээж авч шалгана.

7.3 Суулгацын өвчин, хортон шавьжинд нэрвэгдсэн байдлыг MNS2783:1979 “Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн. Мөөгөнцөрийн өвчнийг илрүүлэх арга”, MNS 2784:2007 “Ургамал, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн. Бактерийн гаралтай өвчнийг илрүүлэх арга”, MNS 2782:79 “Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн. Хортон шавьжийг илрүүлэх арга” стандартуудын дагуу тус тус тодорхойлно.

7.4 Суулгацын өндрийг шугамаар, голчийг штангенциркулиар хэмжинэ.

8. САВЛАЛТ, ШОШГОЛОЛТ

8.1 Савалсан суулгацыг тээвэрлэхэд зориулан үндсийг гадны нөлөөллөөс бүрэн хамгаалах хэмжээний нийлэг хальс, таар шуудайн дээр чийглэсэн үртсийг жигд тараагаад, суулгацын үндсийг шороон зуурмагт хутгаж үзүүрийг нэг тийш нь харуулж тавиад өөр хоорондоо үрж холхихгүйгээр модны үртэс буюу шороогоор хөдөлгөөнгүй чигжисний дараа битүүлэн ороож бооно.

8.2 Багцалж боосон суулгацыг дахин гадуур нь тааран шуудайнд савлана.

8.3 Чавганы суулгацыг 25 буюу 50 ширхэгээр боож, шошгыг тээвэрлэлтийн үед тасарч гээгдэхээс хамгаалан боодлын гадна ба дотор талд зүүнэ.

а/ Боодлын дотор зүүх шошгыг 7 см урт, 5 см өргөн модон эсвэл зузаан цаасаар хийж дээр нь зөвхөн сортын нэрийг бичнэ.

б/ Боодлын гадна зүүх шошгыг 10 см урт, 8 см өргөн хэмжээтэй хийнэ. Шошгыг баларч арилахаас хамгаалсан байна.

8.4 Савласан суулгацанд дараах мэдээлэл бүхий шошго, зааврыг дагалдуулна.

- Суулгац үйлдвэрлэгч байгууллага, аж ахуй нэгж, иргэнний нэр, хаяг,
- Стандартын дугаар, тэмдэглэгээ,
- Сортын нэр,
- Суулгацын тоо, ширхэг,
- Хадгалах хугацаа, нөхцөл,
- Тарьж ургуулсан он,
- Тарьж суулгах, заавар.

9. ХАДГАЛАЛТ

9.1 Мод үржүүлгийн газраас авсан суулгацыг тарих хүртэл түр хугацаагаар хадгалах тохиолдолд суулгацын үндэсний хэсгийг 15-аас 20 см хүртэл зузаан үетэй чийгтэй шороогоор булна.

9.2 Намар хүлээж авсан суулгацыг өвөлжүүлэх бол 30-аас 40 см гүн шуудууг салхины хөндлөн чиглэлд татаж, суулгацыг шуудуундаа салхины ноёлох зүгийн тараан дагуу налуулж эгнүүлэн тавиад үндэсний хэсгийн 30-аас 40 см зузаан хар шороогоор булж ханатал усалж хадгална.

9.3 Хадгалалтын хугацаанд мэрэгчид болон мал, амьтад суулгацыг гэмтээхээс хамгаалж татаж услах, эргэн тойронд хорт өгөөш тавих, нарийн тороор хаших, хор өгөөш тавих ба цас ормогц хөрсний гадаргуу дээр ил байгаа иш, мөчрийг цасаар нягтруулан дарна.

10. ТЭЭВЭРЛЭЛТ

10.1 Савласан суулгацыг тээвэрлэхдээ тээврийн хэрэгслийн тэвш, хашлага дотор доор нь 10-аас 15 см зузаан зөөлөвч дэвсэж босоо байдлаар эгнүүлэн тавьж ачих бөгөөд боодлын хоорондох зай завсарт чийгтэй үртэс бүхий шороогоор чигжиж дүүргэнэ. Хол тээвэрлэх тохиолдолд үндсийг тогтмол чийглэж хатахаас хамгаалах арга хэмжээ авна.

10.2 Савласан суулгацыг нарны шууд тусгалаас хамгаалж сэрүүн нөхцөлд тээвэрлэнэ

10.3 Савласан суулгацыг хэт хүнд зүйлээр дарж бяцлах, уут задарч үндэс ил гарахаас сэрэмжлэх, шатах дэлбэрэх, бохирдуулах бодистой хамт тээвэрлэхийг хориглоно.

10.4 Тээвэрлэлтийн нэг удаагийн хугацаа 4 хоногоос хэтрэхгүй байна.

ТӨГСӨВ.